

МОНГОЛ ХЭЛНИЙ “i-na-ru, ċi-na-ru” ХЭМЭЭХ ҮГИЙН УЧИГ, УНДАРГА

Ч. Бямбаханд *

Түлхүүр үг: 1. “i-na-; ċi-na-” язгуур бүтээвэр
2. “-ru” залгавар бүтээвэр

Орон цагийн утга заасан ‘i-na-’, ‘ċi-na-’ хэмээх язгуурт ‘-ru’ залгавар залгаж орон цагийн ойртолт, алслал бүхий орон цагийн харьцаа заасан үг үүснэ.

“Монголын нууц товчоо”-нд ‘i-na-ru, inerü¹ (inaru)² i-na-du, i-na-γsi, i-na-γsi-da, inaγun’, ‘ċi-na-du, ċi-na-γsi, ċi-na-γsi-da, ċi-na-γun’ зэрэг үг тохиолддог.

Алтай язгуурын зарим хэлэнд хэлний урдуурх эгшигтэй үгэнд бүх гийгүүлэгч тохиолддоггүй. Түрэг хэлний ‘k, g’ гийгүүлэгч зөвхөн хэлний урдуурхи эгшигтэй үгэнд тохиолдож байхад ‘q, g’ эсвэл ‘γ’ гийгүүлэгчүүд зөвхөн хэлний хойгуурх эгшигт үгэнд тохиолдоно. Тиймээс дээрх гийгүүлэгчид бүхий залгавар бүтээвэр нь ‘-kă, -gă, -qa, -γa’ хэлбэрээр тохиолдоно. Жишээлбэл: эртний түрэг хэлэнд: ‘süg’ цэргийг, ‘at-i-γ’ морийг, ‘il-găru’ урагшаа, ‘qurċi-γaru’ хойшоо, ‘ödkă’ эдүгээд, ‘taluyqa’ тэнгист гэх мэт. Энэхүү

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Хэл шинжлэлийн тэнхим

1) Д.Цэрэнсодном. “Монголын нууц товчоон” дахь “*yekes-ün γajar-u inerü*” хэмээх хэллэгийн тухай, (товчлол), Антоон Мостаэрт ба монгол судлал. Уб., 2011. 318-р талд “Монголын нууц товчоог” сэргээн сийрүүлсэн судлагчдаас Цэнд гүн, өвөр монголын эрдэмтэн Ихмянгадай Иринчин, профессор Ш.Гаадамба, доктор Б.Сумьяабаатар нарын эрдэмтэд бидний энд авч үзэж буй “*inerü*” хэмээх үгийн орчин цагийн монгол хэлний “янад” гэсэн утга бүхий *inaγu* гэсэн үгээр ухаж буулгасныг юуны өмнө тэмдэглэн хэлье... гээд “Нууц товчоо”-ны *γajar inaγu* буюу “газар дөт”, “газар янад” хэмээх эл үг нь хатдын хүрээнд ёсолдог тахилга тайлгыг нэрийдсэн профессор А.Мостаэртын хэлснээр нэр томьёоны шинжтэй тогтсон хэллэг байжээ гэсэн дүгнэлтэнд хүргэж байна... гэжээ.

2) Бид энэхүү судалгаанд “Монголын нууц товчоо”-ны үгийг тайлбарлан шүүж тунгаах бус уг үгийг сурвалж бичгээс жишээлэн дурдаж, өгүүлбэрийн байрлал хэлзүйн холбоосоор нь гаргахыг оролдсон болно. Энэхүү үгийн язгуурын нэгдүгээр үед саармаг шинжтэй “i” авиалбар орсон учраас судлаачид эгшиг зохицох ёсоор “*inerü*” гэж галигласан байж болох юм. Харин бид “i-na-du, i-na-γsi, i-na-γsi-da, inaγun” гэсэн үгээс үүтгэн бодвол дээрх эрдэмтэн мэргэдийн адил “*inaγu*” хэмээн тэмдэглэх боломжтой бөгөөд бидний харсан хэлзүйн бичгүүдэд “*inaγu*” гэж галигласан байна. Мөн бид “*yekes-ün γajar-u inerü (inaru) γaruγsan-dur...*” гэх хэллэгээс “...*γaγar-u inaγu γaruγsan-dur...*” хэмээхэд орны байцын үүргээр эс тусах үйлийн бүлэг болж байна.

нармайн угийн, тагнайн хойгуурхи гийгүүлэгчдийн эгшгийн хойгуур, урдуурх шинжээс хамаарах үзэгдлийг гийгүүлэгч зохицох ёс гэнэ.³ Ийм учраас монгол хэл нь залгамал бүтэцтэй тул эгшиг, гийгүүлэгч зохицох ёс чухал боловч ‘i-na-; či-na-’ гэсэн язгуур бүтээврийн араас “-ru” залгавар бүтээврийг шууд залгана.

И.Я.Шмидт inadu-diesseits (энэ тал), činadu- jenseits (тэр тал) (postposition)⁴ зэрэг үгийг дагавар үгийн хэсэгт хамруулаад ‘kiʃaγār-ūn činadu’ (хязгаарын чинад) гэж жишээ дурдаад мөн ‘inagu’⁵ эсвэл ‘inaγsi’ herwärts (наашаа, дотогшлох), ‘činaγsi’ weiter, abwärts (цаашаа, гадагшлах) (adverbium)⁶ гэх мэтээр дайвар үгийн үүрэгтэй хэмээн тэмдэглэжээ.

Энэ үгийн язгуурыг Г.Рамстедт ‘nā’ ‘энэ тал, наана’ гэх язгуур нь kanāwīn nā ūkūrīn χāgūl жалганы наагуур үхрээ хариул, nād^o (ūlīn nād-wij^o(n)də) уулын наад биед, nār-talār᠓ наад талаар нь, nāγās энэ талаас, наанаас ‘nāγān, nār᠓’ нааш, наашаа ир, ийшээ ир, ‘nār гэхэ’ дуудах урих утгатай үг, ‘nār|χ^o’ ойртох, ‘nār|dž sū’ наашаа суу, наашлах, ‘nār|ūlχ^o’ нааш авчрах, [ina-, gaγu, la-] ‘nār᠓’ нааш иргэдэг нь nār᠓ гэдгээс үүссэн. Жишээ нь: ‘Ēi kūkūt nār᠓’ Хүүхээд нааш ир!⁷ гэх мэтээр илэрдэг гээд мөн tsā –ард, цааш, арагш жишээ нь: tsān jaks᠓ medsn-ugĒ “цааш яасныг мэдсэнгүй” [vgl. činadu, činaγsi; vgl.tu (MA VIII 383)] čai,da,- čai,du “ард, арагш” ma.ča,la id.], tsāγās –хойноос, тэндээс, tsāγūr –цаагуур, tsākšī> tsā хойшоо, буцах, эргэх жишээ нь: tsākšān id. (tsārān) tsār ба tsārān –цаашхан, буцах жишээ нь: tsārān bā –цаашаа яв, nār᠓ tsār᠓-наашаа цаашаа, tsārānki-онцгой, цаашхи, цаашид, tsār|χ^o-цааш явах, tsār᠓- tsārān, tsāt^o tsād-ард, өөр зүйл, nad^o tsād^o bij –наад бие цаад бие, наад цаад тал, tsād talās᠓- араас нь, нөгөө талаас нь, nāt^o tsat^o наадах цаадах⁸ гэж дээрх хоёр үгийн гарлыг гаргажээ.

Энэ үгийг “Хорин наймтын тайлбар толь”-д: “inaγsi” биеийн зүг ирэхийг буюу бас өнгөрсөн цагаас одоод хүрж ирэх хоорондын хугацаа юм. Жишээ нь: “erten-eče inaγsi” эртнээс нааш, inaγsi irekū биеийн зүг ирэх, inaγsi boluγsan биеийн зүг ойр ирснийг “инагш болсон”, наашлах- ойртох гэсэн үг, inaγsi qolkiʃu алив хивлэгт мал адгуус өвс идсээр түр зогсвоос мөн даруй гүзээ дэх өвс нь өөрийн эрхгүй угшин гарч амны дотор ирэх, inaγsi činaγsi нааш цааш явахыг буюу тийнхүү эсэргүү зүглэснийг инагш, эсрэг зүгт чиглэснийг činaγsi хэмээж, эсрэг тэсрэг зөрчилдөн явах, inaγsi činaγsi ūgei –нааш цааш хөдлөхгүй, боломжгүй, inaγsi činaγsi yabuqu нааш цааш одохуй буюу “inaγsiqan”, - “inaγsiqan>inaγsida>inadu (алив юмыг наана дахийг нь “inadu”) гэнэ, inadu-аца činadu-dur

³) Н.Поппе. Алтай хэл шинжлэлийн удиртгал. Уб., 1999, 239-р тал

⁴) I.J.Schmidt. Gramatik der Mongolischen Sprache. St.Peterburg, 1831. Seite-86

⁵) I.J.Schmidt. Gramatik der Mongolischen Sprache. St.Peterburg, 1831. Seite-94

⁶) I.J.Schmidt. Gramatik der Mongolischen Sprache. St.Peterburg, 1831. Seite-95

⁷) G.J.Ramstedt. Kalmückisches Wörterbuch. Helsinki, 1935. SUOMALAIS- UGRILAINEN SEURA, Lexica societatis Fenno-Ugricae III, 273b

⁸) G.J.Ramstedt. Kalmückisches Wörterbuch. Helsinki, 1935. SUOMALAIS- UGRILAINEN SEURA, Lexica societatis Fenno-Ugricae III, 423 b

odqu-энэтээгээс тэртээд хүрэхийг нь буюу энэ этгээдээс тэр этгээдэд хүрэх, inadu Јаqa-газар орон ба уул ус гол мөрний зэрэг алив юмын наана дах хязгаар хөвөө, “inagu” - урьд гэх утгатай үг буюу урьдаас хэмээн дурдан хэлэхэд хэрэглэнэ. Жишээ нь: olqu-yin inagu, бүтүкү-yin inagu, күг-кү-yin inagu.⁹ гэх мэт. Харин činaysi- цаана бол хэмээн өгүүлэх болвоос činaysi, činaysiqan- их холыг činaysiqan, činadu-голын цааныг činadu буюу аливаа тэртээ цаана ахуйг činadu, жишээ нь: činadu kiЈayār kúrúgsen-цаана захад хүрснийг činadu kiЈayār kúrúgsen мөн bilig-un činadu kiЈayār kúrúgsen-ú nom kemegsen metú buyu činaduki¹⁰ гэх мэтээр язгуурыг гаргасан байна.

Эндээс үзвэл “i-na-”, “či-na-” хэмээх идэвхигүй язгуурт үгийг авч үзвэл: čina-ru, čina-γši, čina-du, činādu, činaysi> čayān-a, čayānaki, čayānaqan, čayānduqu, čayāqan-a, čayāqanayūr, (činadu)čayādu, čayāduki(činaduki), čayāduyula, čayāru(čāši) čāši, čāšiki, (činaysila-qu) čāsilaju, čāsilaju (činaysida)čāšida, (činādu)čādu; činā-duki; > čiliyi-, či~ta > taliyaqu, čig; ina-ru, ina-γši, ina-du, inayūn, inadu, inagu>ina->nā-(“i” гээгдэж), inayūn, inayūr, nayān-a, nayāqan, nayāyūr, nayāyūrlaju, nayāyūrduqu, nayāsi(nāsi), nayāsilaqu(nasilaqu), nayāduki(nayā-daki), nayāduyūla, nayāru, nāsi, nāsilaqu(inaysilaqu)гэх мэт хэлбэрүүд үүсч байна.

“inagu” гэх үг нь дундад үеийн түрк хэнд: nāru, халимаг хэлэнд nār-ān, tsārān; захчин аялгуунд nār, tsār (нааш, цааш), nārīch nārīch (нааш ирээч) гэхээс гадна “ийш” гэх үгийг īgēn, īgān ийшээ, энэ чиглэлд īkšān¹¹ жишээ нь: īšignē ōwōr īgēn tīgēn (ишигний эвэр ийшээ тийшээ), īgēd jowdžū (ингээд яваарай)¹² гэх мэтээр хэлдэг байна. čina-ru>ina-ru, čina-γši> ina-γši, čina-du> ina-du, činaγūn> inayūn гэх мэтээр үе утгалбарын эхний гийгүүлэгч гээгдэж (үе утгалбар задгайрах¹³) улмаар “inagu” гэх үгийн “i” ба нэгдүгээр үед байсан эгшиг дээр өргөлт ирэхгүй 2-р үе дээр буй “a” дээр өргөлт оногдсоноор umartaqu-martaqu гэх үг шиг ‘inagu>nāru>nār’ гэж эхний “i” эгшиг үүрэггүй болж, сүүлчийн эгшиг нь эртний түрэг хэлний адил turk: ‘gök’хөх =mo. ‘kōūke’хөх, эртний түрэг: qon-*qona ‘шөнийг өнгөрөөх’, mo.qono-ММо. qona- “шөнийг өнгөрүүл-, хоно-” гэх мэтээр төгсгөлийн эгшиг нь гээгдсэн гэж болно. “inagu, činagu” хэмээх үг нь ихэвчлэн сонгодог монгол бичигт тохиолдох бөгөөд ярианд болон орчин цагийн монгол хэлнээ хязгаар тавьж буй орноос нааш гэсэн утгаар нааш ир, нааш хандах, нааш зүглэх; хязгаар тавьж буй орноос цааш гэсэн утгаар цааш яв, цааш хандах, цааш зүглэх хэмээн орны утгаар, сараас нааш ирэхгүй, энэ мөчөөс цааш гэхэд тогтсон хэм хэмжээ, цаг хугацааны дотор цагийн утгыг ялган гаргасан гэж болно.

⁹⁾ Хорин наймт тайлбар толь. ӨМАХХ., 1988. 274-р тал

¹⁰⁾ Хорин наймт тайлбар толь. ӨМАХХ., 1988. 1803-р тал

¹¹⁾ G.J.Ramstedt. Kalmückisches Wörterbuch. Helsinki, 1935, SUOMALAIS- UGRILAINEN SEURA, Lexica societatis Fenno-Ugricae III, 213b

¹²⁾ Ж.Цолоо. Захчины аман аялгуу. Уб., 1965. 148-р тал.

¹³⁾ М.Базаррагчаа. Эртний монгол хэлний үгийн бүтэц, түүний зарим онцлог. Уб., 2005 гэх бүтээлийн 70-р талд үе-утгалбар задгайрах нь буюу үе утгалбарын эхний гийгүүлэгч гээгдэх нь гээд э-сэ-р-гү тэ-сэ-р-гү, э-йи-мү тэ-йи-мү... гэх мэтээр түүхэн бүтээвэр судлалын үндсэн нэгж болох үе-утгалбарын тогтолцоог гаргажээ.

2. “ina-ru”, “ċina-ru” хэмээх үгэн дэх “-ru” залгаврын тухай

Ш.Лувсанвандан “хоёр өөр хэлбэртэй, утгатай хэсгийг нэг морфемын хоёр хэлбэр үү, эсвэл хоёр морфем уу гэдгийг ялган тогтооход орчин цагийн хэл шинжлэлд нөхөх байрлалын зарчим гэгчийг хэрэглэдэг¹⁴ гэжээ. Ийм учраас “-ru, -du, -ši” нь нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдож байгаа учраас энэ нь нөхөх байрлалын зарчмаар бие даасан залгавар бүтээвэр гэж болно.

2а. -ru/гү~-га, -ге

Г.И.Рамстедт “-ru¹⁵/гү” залгавраар төгссөн тийн ялгалын хувиргал нь түрэг, монгол, солонгос хэлэнд тодорхой байдаг гээд хаашаа гэсэн үгэнд хариулагдах чиглэл заасан утгатай энэхүү төгсгөлтэй үгсийг бас зорилго заасан тийн ялгал, эсвэл чиглэл заасан гэж нэрлэж болно гээд

1. Түрк хэлэнд atú. abimrú (миний гэр рүү), äbim (миний гэр), эрт үед бас bärú(ийшээ), (bän-ээс (би)), агу-тийшээ (ан-тэр гэсэн төлөөний үгийн язгуур), уйгур: kirú<*kärú (буцах, эргэх, зам) якут: kiär, alt. tel. jary, jar (-руу, хүртэл, тийш(чиглэл), уан “зүг, тал) гэх утгаар хэрэглэж байсан. Өгөх оршихын тийн ялгалын дараа энэ төгсгөл нь байсан бөгөөд -үагу гэх залгавар нь бүтээлч хэрэглэгдэж байсан гээд qaγanγaγu (хаан руу), bizgärú (бид нар луу), bizingärú (манай гэр лүү), tašqaru, tašγaru (гадагшаа), osm: dyšary, ičkärú, ičgärú (дотогшоо), osm: ičäri, ilgärú (урагш, урагшаа), osm: iläri, joqaru, joγaru (дээшээ) гэх мэт. Уйгур хэл болон хожмын зарим аялгуунд өгөх оршихын нөхцөлөөр хэлбэржиж байсан. аңар тиңар (түүнд, энд) гэхийн зэрэгцээ хожим киргиз хэлэнд оңан (оған), тиңан (энд), маған (надад), саған (чамд) гэж хэлж ирсэн. Энэ нь “-үагу” гэх хэлбэртэй болжээ.

2. Монгол хэлэнд “-ru/гү” төгсгөл нь янз бүрийн аялгуунуудад тохиолддог боловч бичгийн хэлэнд энэ тийн ялгалын хувиргаа хэрэглэгддэггүй. Жишээ нь: mo.*qagaγu (хаа руу)~qaru>kalm: xār-ān (хаашаа), mo. inaru (=inagsi) > kalm. nār-ān ийшээ, kh. modorū (ой руу, ойн эсрэг талаас), golrū, golurū (гол руу) (төв рүү нь), gerlū (хоёр ‘r’орсон тохиолдол ‘r’болж ондоошно жишээ нь: (гэр өөдөө, гэр лүү, morilū -морь луу) гэх мэт. Энэ төгсгөл нь гийгүүлэгчээр төгссөн үгийн дараа *uru гэх хэлбэрээр харин эгшгээр төгссөн үгийн дараа -ru гэх хэлбэрээр тохиолддог. Мөн баруун монголын хэлэнд -ür гэсэн холбох эгшгийн уртатгалаар төгссөн хэлбэрээр тохиолдоно. жишээ нь: golūr (гол руу), gerūr (гэр өөд), usūr (ус руу) гэх мэт. Харин урт эгшгээр төгссөн үгэнд “-g” холбох гийгүүлэгчээр “-gur” хувилбараар илэрдэг. Жишээ нь: хōgūr хō’gūr (хойшоо) хойгуур, nāgūr (энэ талаар, энэ зүгээр, энэ замаар) гэх мэт. Бусад аялгуунд “-ür –gūr” гэсэн хэлбэрээр тохиолддог бөгөөд -ru гэх төгсгөл нь аялгуундад тохиолддог гэхдээ энэ нь утгын хувьд ялгаатай болохыг тогтоож байна. Жишээ нь: usūr (ус руу, ус өөд, чигээрээ), usūr (ус руу орох эсвэл ус дагуу)

¹⁴) Шадавын Лувсанвандан. Бүтээлийн чуулган. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Уб., 2010.130-р тал.

¹⁵) G.J.Ramstedt. Einführung in die Altaische Sprachwissenschaft, II Formenlehre, Helsinki 1952, Seite-32, a.tü: baγaru ‘надад, надруу’

3. Эрт дээр үеэс л солонгос хэлэнд тийн ялгалын хувиргал нь олон янзаар хэрэглэгдэж байсан. Зорилго заасан тийн ялгал нь өмнөд солонгосын хэлэнд “го” хойд солонгост *gu* (*gi*), *illi* (*ili*) гэх хэлбэрээр илэрдэг бөгөөд эдгээр нь эртний ‘-*gu*~-*gü*’ -д холбогдох бөгөөд “замаар, зам дундуур, зам дагуу, дундуур, -аар” гэх мэтээр чиглэл заасан хэлбэрээр тохиолддог. Энэ нь орчин үеийн солонгос хэлний хэлзүйд үйлдэхийн тийн ялгалын хувиргалаар илэрнэ. жишээ нь: *sanġro* (уул дагуу), (уул руу, уулаар) гэх мэт. Хойд солонгос: *ċibuġu*; *allo* (доошоо), өмнөд солонгос: *mullo* (усны эсрэг, ус дагуу, усан дундуур, усаар) гэх мэт. Хойд солонгос: *mullu*, *muġuru* (ус өөд) гэх ба *muġilli*, *muġullġ* усаар, усан дундуур гэх мэт. Энэ тийн ялгалын хувиргал нь ихэвчлэн тохиолдох болсон ба эртний хэлбэрийн хэрэглээнд аналогоор хувирч байна. Энэ тийн ялгалын онцлог нь турк хэлэнд “*ru*”, монгол хэлэнд “*ru*” гэх хэлбэрээр илэрдэг. Энэ тийн ялгалын хувиргал нь эртний солонгос хэлэнд өгөх оршихын айтай холбогдсон. Авиан зүйн хуулиар эхэн үедээ *-*ru*-*ai*, *-*ru*-*ei* гэж бичиж байснаа одоо “*lai*, *lei*” гэж бичиж “*lā*, *-le*” гэж ярьж байна. Хойд солонгосын хэлэнд энэ тийн ялгалын хувиргалаар хувирах нь түгээмэл байдаг. жишээ нь: *abillā* (аавдаа, аавд зориулж), *nallā* (надаа), *meġkillā* (хоолондоо, идэхийн тулд, хооллохын тулд), *kagillā* (явахын тулд, явахаар) харин өмнөд солонгосын хэлтэй харьцуулахад зөвхөн “-*ki*-*llā*”, гэх хэлбэрээр өөрөөр хэлбэл нь нэршсэн үйлийн дараа дээр залгана. бидний үзэж байгаагаар солонгос хэлэнд “-*ru*+өгөх оршихийн тийн ялгал” залгах ба түрк хэлэнд үүний эсрэгээр “*ya*-*ru*” хэлбэрээр тохиолдоно.

4. Солонгос хэлний энэ төгсгөл нь түнгүүс хэлэнд тохиолдвол бидний үзэж байгаагаар *-llā*, *-llā̄* эсвэл *-lā*, *-lā̄* хэлбэрээр илэрч байна. Үнэндээ түнгүүс аялгуунд (өмнөд, хойд түнгүүс хэлний хэсгүүд ч гэсэн) тийн ялгалын *-lā*, *-lā̄* төгсгөлөөр болон (*adessivus*-*allativus*) утгаар илэрнэ. (хэнд, хэн рүү, хэний) энэ нь солонгос хэлний хэрэглээгээр тодорно. Жишээ нь: манж: *dele* (дээр), *dolo* (доор, дотор), *de*- (дээд), *do*- (дотор), *ebele* (энд, ийш), *ubala* (тэрэнд) (<*e*-энэ, *ba*-орон газар), түнгүүс: *samandula* (бөөд, бөө рүү), *algala* (гарт) аялгуунд *halgala* нанай хэлэнд: *palgalā* (*ma.falga*) (гарт, алганд, алган дотор), монгол хэл: *alaga*, халимаг хэл: *alᠬa*; солонгос хэлэнд: *phal* (‘*gar*’, ‘*хоосон gar*’), *lālā* (хаана, хаашаа), (С.Радлов I-1478) *iläisā̄* (хаана бас байна) < *ilä* *ersā*, *talā* (тэнд, тийшээ), *elālā* (энд), монгол: “-*la*” аас чухамдаа “-*du*”-р төгссөн үгэнд гарахын тийн ялгал залгаж “-*duki*, *-duk*” үүссэн шиг бас “-*la*” гэсэн тийн ялгал нь хаанаас гэсэн утгаар хэрэглэгдэнэ. Мөн “-*lāki*, *-lāk*” төгсгөлтэй үг нь солонин хэлэнд: *ilāk* (хаанаас), *talāk* (тэндээс), *algalāk* (гараас), *gulāk* (гэрээс) гэх мэт. Түнгүүс хэлний элемент “-*lā*” нь солонгос хэлний тийн ялгалын төгсгөл нийлсэн төгсгөл байдаг. Жишээ нь: “-*ru*-*ai*” нь - одоо “-*llā*” ээс тодорхой байна. Энэ нь түнгүүс хэлний *-li* төгсгөл нь солонгос хэлний “*ru*”- тай холбоотой¹⁶ гэж түрк, монгол, солонгос хэлний жишээгээр тайлбарлан үзжээ. Энэ дурдсан хэсэгт бидний судлаж буй “-*ru*” –д зарим ойлголт нь хамаарч байна.

¹⁶ G.J.Ramstedt. Einführung in die Altaische Sprachwissenschaft, II Formenlehre, Helsinki, 1952. Seite-38

өвөг алтай хэл	өвөг түрк, эртний түрк	өвөг монгол хэл, сонгодог бичгийн монгол хэл	эртний түнгүүс	эртний солонгос, дундад үеийн солонгос
allative:-/gV/	-/ɣaru/, -/gery/	*-ɣa, -a	-gi:	ei
directive:-/rV/	-/ɣaru/, -/gery/	-ru		ro /lative/

гэж¹⁷ бидний авч үзэж буй ‘-ru’ -г түрк хэлний чиглэх утгатай -/ɣaru/, -/gery/ тийн ялгалын нөхцөл, солонгос хэлний “ro”- той адилтган тэмдэглэсэн байна. Гэтэл ойрд дуунд:

Хоо толхаад бууснаас хоор

Хой тогтохыг уурлаа даа

Хонгор чамааг явснаас хоор

Сэтгэл тогтохыг уурлаа көө¹⁸ (АГХД-343) гэхэд хойш гэсэн үг нь “хоор” буюу “бууснаас хойш” “явснаас хойш” гэж цагийн утгаар орсон бөгөөд энэ үгийг Г.И.Рамстедт хōg, хōg dund, хōg zūr oɣxow, хōrākšan (ardākšan, tsārān, хōrān), хōrān хōrn, keltēn urālŋ, keln-ŷgēn хōrān¹⁹ гэж тэмдэглэсэн байна. Эндээс үзвэл “-ru” нь чиглэх утгатай төдийгүй, дээрх дуунд цагийн утгаар орон цагийн нэрнээ тохиолдож байна.

Цэцэнцогт²⁰ “-ru” нь “г, г-а” тай гарал язгуур нэгтэй. Үүнтэй тохирох дагавар зүүн ёогур хэлэнд “гэ” na:gar (наᠮᠠᠭᠠᠷ-түрүү хэдэн өдөр, түрүү удаа), tʃinaə (čina-ru > nōgūgedūr) гэх мэт. Манж түнгүүс төрлийн хэлэнд бас “-ro, -ri, -rgi” гэх мэт хэлбэр буй. Жишээ нь: tʃoro (činaru > nōgūgedūr), dobori (шөнө), tʃimarī (маргааш), tʃargi (čina-ru > цаана) гэх мэт. Мөн **ina-** >ina-ru (наана), наᠮᠠᠭᠠᠷ, qoɣuru, čina-ru, саᠮᠠᠭᠠᠷ, manaɣaru, qamiɣaru, turɣa (турш), ru>turqaru~ tursi, nasun turɣaru гэх мэт жишээгээр “-ru” залгавар бүтээврийн онцлогыг гаргажээ.

Эндээс үзвэл монгол хэлнээ: 1. уруу (uruɣu) (уруу≠ өөд, уруу газар, уруу царай, уруудах гэх хэлбэрээр тохиолддог) 2. “-руу, -рүү~-луу, -лүү” (зүг, чиглэл заасан)үүнийг зарим эрдэмтэн тийн ялгал гэж үздэг. 3. “-руу” (нэр үг үүсгэх дагавар) жишээ нь: omu(-i)-ruu а.амьтны өвчүү цээж б. үхрийн омруу, usu-ruu а. ус нэмэх хэрэгсэл, neti-rūū-юмны хэт муу бөгөөд доор болсон байдал, balta-ruu- дээсний ~, balci (-i)-ruu –хөлийн салаанд гарах усан бижрүү, holcu-ruu а.юмнаас хэлтэрсэн жижиг хэсэг, модны~ б.юмны өнгөн талд гарсан хатуурхаг зүйл, homhu-ruu ~ qoɣjiraqu, hōntū(-i)rūū~ханз,~тэргэ унаганд халтай в.энэ тал нь өндөр тэр тал нь уруу байдал, ~газар, gubu(-i)-ruu²¹ гэх мэт. 4. “-ру” (дүр байдал заасан дагавар) tobu-ru (маш тодорхой болох буюу бусдаас ялгаран гарсан байдал), tomu-ru (юмны нилээд их байдал), соуи-ru (а.юманд онгорхой нүх гарах б.олноос оройлж гарах в.ухаан орох)²², quyu>quuru, sau>sa`uru>сауuru, delbe>delberū, tasu>tasuru, суу>сууuru 5. бидний ярьж буй “-ру” (орон цагийн утгат дагавар) “i-na-ru”, “čina-ru” гэх үг эртний болон сонгодог монгол бичгийн хэлнээ тохиолдох хэлбэр нь “-г,

¹⁷⁾ http://en.wikipedia.org/wiki/Altaic_languages

¹⁸⁾ Г.Гантогтох. Монгол хэлний нутгийн аялгуу. Уб., 2002. 17-р тал

¹⁹⁾ G.J.Ramstedt. Kalmückisches Wörterbuch. Helsinki, 1935. SUOMALAIS-UGRILAINEN SEURA, Lexica societatis Fenno-Ugricae III, 192b

²⁰⁾ Цэцэнцогт. Монгол хэлний язгуурын толь. ӨМАХХ. 1987. 2861-р тал.

²¹⁾ Д. Баатар. Монгол хэлний үүсмэл үгийн тонгоруу толь. ӨМАХХ., 1988. 2036-р тал.

²²⁾ Д. Баатар. Монгол хэлний үүсмэл үгийн тонгоруу толь. ӨМАХХ., 1988. 2239-р тал.

-г-а”- тай гарал язгуур нэгтэй төдийгүй орон цагийн утгатай нь тодорхой байна. Иймд эдгээр олон хэлбэрийн утга хэрэглээг нарийн судлан гаргах хэрэгтэй юм. Манж хэлэнд “baru” гэх үг нь (ǰúg, uгуү, -dur, -tur) гэх утгатай байна.

2б. “-du”

i-na-du > *nād > nād, činadu > tšinād гэхэд тохиолдож буй “-du” нь тодотгох үүрэгтэй хамжсан тодотголын үүргээр ордог бүтээвэр бөгөөд орчин цагийн монгол хэлэнд зарим язгуурт шууд залгагдан язгуур, залгавар бүтээвэр гэж салган үзэх боломжгүй болж, зарим үгэнд огт залгаж болдоггүй. Жишээ нь: qoyidu, uridu/urida (цаг), urdu (орон), emūnedú, dorunadu, ōrūnedú, umardu, qoǰid, degedú, dorud, दौरadu, degedú, qoyisida, egúrde, imayта, ōnide, úrgelǰide, mǒngkede, asida, inaysida, uruγsida, dergede, degeside, gadayādu, dangdā, keǰigede, nasuda гэх мэт.

2в. “-si” “-γsi” “-gsi”

i-na-γsi (нааш, ойртох), i-na-γsi-dā (наашдаа), či-na-γsi (цааш, цаашлах) či-na-γsi-dā (цаашдаа) гэсэн идэвхигүй язгуурын ард орж буй орон цагийн утга бүхий “-si” дагавартай үгсийг М.Базаррагчаа marγāsi, či-na-γsi, i-na-γsi, teγsi, eyisi, γadaysi, dotuγsi, uruγsi, qōyisi, qōyinaγsi, barayūnsi, ǰegūnsi, emūnesi, degēgsi, doγūγsi, tursi, údesi, aruγsi, dorunasi, ōrūnesi, umarasi, doruγsi, qamiγāsi, yāyisi~yāsi ...гээд энэ “-si” дагавар нь язгуурын “-si-” үе утгалбараас үүсэлтэй бөгөөд энэ нь “өчүүхэн”, “нарийн ширийн” гэсэн утгатай тул тухайн юм нөгөөд орох шингэх боломжийг заасан гол утга үүсэх ба улмаар шингэн зүйлс, тухайлбал, ус бороо газарт шингэн ордог гэсэн утгаас дээрх үгс үүсчээ. Ийнхүү нэгээс нөгөөд орох, шилжих, цаашилбал, нэгээс нөгөөд хандах гэсэн утга бүхий “-γsi, -si” гэсэн дагавар салаалжээ.²³ гэж үзжээ.

Монгол хэлний “i-na-ru, či-na-ru” хэмээх үгийн учиг, ундрагыг тунгаан үзвэл:

Авиан зүйн онцлог: I.a. i-na-ru > *nā-ru > nār; б.i-na-du > *nād > nād в.i-na-γsi > *nāsi > nās > nāš+ā II. а. či-na-ru > tsāru > tsār; б. činadu > tšinād, в. činaγsi > tsāš > tsāš+ā

Бүтээвэр зүйн онцлог: “i-na-ru”, “či-na-ru” гэх үгийн эсрэгцэл нь сонгодог монгол бичгийн хэлнээ уламжлан ирсэн бөгөөд орон зайн хоёр талын эсрэгцэл заах бөгөөд ‘i-na-ru’ нь тодорхой хязгаартай, харин ‘či-na-ru’ нь тодорхой бус хязгааргүй утгыг илэрхийлсэн нэг талаас орны, нөгөө талаас цагийн харьцааг илэрхийлэхэд харьцангуй хэрэглэгддэг идэвхигүй язгуурт “-ru” залгавар залгажээ.

залгавар: “-ru, -γsi, -gsi, -si, -du”

үүрэг, утга: орон цагийн нэр бүтээнэ, орон цагийн харьцаа заана

холбоо байр, зохицол: “-ru” залгаварт үг нь үйл үгийн өмнө, “-γsi, -gsi, -si” залгаварт үг нь үйл үгийн өмнө, “-du” залгаварт үг нь нэр үгийн өмнө тохиолдоно.

Жишээ нь: inaru²⁴ II-70-2, “yebes-ūn γajar-u inerū (inaru) γaruγsan-dur...” (орны утгат байц)

²³⁾ М.Базаррагчаа “-γsi” буюу “-si” дагаврын гарал утга. МУИС, МХСС, ЭШБ., XXVI боть IV дэвтэр, Уб., 2006, 19-р тал.

²⁴⁾ Б.Сумьяабаатар, Монголын нууц товчоон, үсгийн галиг, Уб., 1990

1908. inayṣi 12a 01, 20b 02, 24b 13, 24 b23, 41b 07/ 2a 19. ...maq-a samadi qaṣan-u altan uruṣ-aṣa inayṣi saluṣan... (цагийн утгат байц)

1909. inayṣida 1a 05, 43b 01/ oom suwasti siddam erkin bodisūg-nar-un tōrūlten-i: erdem-ten degedū qad-un iṣayur-i enedkeg tōbed-eṣe inayṣida ūndūsūlegsēn-i: (орны утгат байц) edūi tedūyiken quriyan ūgūlesūgei.

976. ṣinayṣi 20b 02/ ...ta nada alba ōgkū bolusa ṣinayṣi inayṣi qarilṣa (n) [qarilṣan] yabuṣtun geṣū Jarliṣ boluṣan-tur [boluṣan-dur] tere Jarliṣ-iyar bolbai.²⁵(орны утгатай байц)

1906. inadu 81b 02/ dayilan yabuba: sayin altan qaṣan qatayūṣin yabuju tangyud tōbed-ūn inadu kiṣayar daki amdoṣ ulus (орны утгатай хамжсан тодотгол)

975. ṣinadu 77a 27 kebtege ōndūyijū ṣinadu kūmūn-i [kūmūn-ū] temūr dōrūgetū kōl-i tasu ṣabṣiba²⁶

Өгүүлбэр зүйн онцлог: i-naru> *nāru>nār; i-na-ṣi> *nāsi> nāš> nāš+ā; ṣina+ru> tsāru> tsār; ṣinayṣi> tsāš> tsāš+ā гэх үг нь орон цагийн утгаар тусах, эс тусах үйл үгэнд захирагдана. inadu>*nād>nād, ṣinadu>tšinad гэх үг нь нэр үгийн өмнө хамжсан тодотголын үүргээр орно. Эдгээр үг нь өгүүлбэрт нэрийн өмнө бол тодотгох үүргээр хамжин орж үйлийн өмнө бол орвол өгүүлбэрт захын дэлгэрүүлэгч буюу байц гишүүний үүргээр орно.

Үгийн сангийн утга нь: Тухайн биед ойр хол буйг заана.

i-na-ṣi (нааш, цаанаас ойртох, янад, янагш, ойр, дөт)

ṣi-na-ṣi (цааш, наанаас холдох, чинад, чанагш, алс, хол)

Утга зүйн онцлог: ‘X is tall’ entails ‘X is not short’, ‘X is short’ entails ‘X is not tall’²⁷ гэсэн утгын эсрэгцэл шиг бидний авч үзэж буй ‘X бол inaru мөн’ > ‘X бол ṣinaru биш’, ‘X бол ṣinaru мөн’ > ‘X бол inaru биш’ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл “...аливаа зүйлийг учир шалтгааны үүднээс танин мэдэж, тэр дагуу зөв шийдвэр гаргах хоосон чанарын үзэл...”²⁸ нь зарим тохиолдолд монгол хэлний язгуур, залгавар бүтээврийн эсрэгцэл үүсдэг шиг энэхүү хоёр үгийн язгуурын утга нь нэг талаас нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн, нөгөө талаас нэг нь нөгөөгүйгээр ухаарагдах боломжгүй утгын эсрэгцэл үүсгэж “нааш, цааш” гэх орон цагийн харьцаа заасан үг үүсгэдэг. “inayṣi ṣinayṣi” нааш цааш явах буюу орны утга заасан хоршоо үгийн үүргээр ч ордог. Жишээ нь: нааш цааш шидэх, нааш цааш явах, нааш цааш хөдлөх, нааш цааш холхих, нааш цааш үсрэх, цааш болох, нааш болох, нааш цааш алхах, нааш цааш шидэх, нааш цааш явуулах, нааш цааш чангаах, цааш нааш нь татах, цааш явах, нааш татах, цааш явуулах, цааш болгох, нааш ирэх, цааш орсон, цааш цааш, цаашаа цаашаа, нааш цааш, наашаа наашаа, нааш цааш гүйх гэх мэтээр хөдөлгөөн заасан үйл үгнээ захирагдах, нааш харж инээж, цааш харж уйлах, цааш ч үгүй болох, нааш ч үгүй, цааш явах, мөнгө цааш хийх, Цааш энэ эрчээрээ! цааш харж уйлах, цааш хийж хадгалах, цааш нь хийж хадгалах, хэзээ нэг цагт хэрэглэхээр

²⁵) Qad-un ūndūsūn quriyangyui altan tobṣi. Тэргүүн дэвтэр. Уб., 2002

²⁶) Qad-un ūndūsūn quriyangyui altan tobṣi, Тэргүүн дэвтэр, Уб., 2002

²⁷) Andrew Radford, Martin Atkinson, David Britain, Herald Clahsen, Andrew Spencer, Linguistics an Introduction, New York 2009, page.175

²⁸) “Цаг хугацаа” сэтгүүл, Уб., 2003, № 03,7, 3-р тал

цааш хийх, цаашдаа, наашдаа, нааштай байдал гэх мэтээр цаг болон хийсвэр харьцаа баймж утгыг илэрхийлнэ.

НОМЗҮЙ

1. М.Базаррагчаа. Эртний монгол хэлний үгийн бүтэц, түүний зарим онцлог. Уб., 2005
2. М.Базаррагчаа “-γsi” буюу “-si” дагаврын гарал утга. МУИС, МХСС, ЭШБ., XXVI боть IV дэвтэр, Уб., 2006
3. Г.Гантогтох. Монгол хэлний нутгийн аялгуу. Уб., 2002
4. Шадавын Лувсанвандан. Бүтээлийн чуулган. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Уб., 2010
5. Ж.Цолоо. Захчины аман аялгуу. Уб., 1965
6. Д.Цэрэнсодном. “Монголын нууц товчоон” дахь “yebes-ün yajar-u inetü” хэмээх хэллэгийн тухай, (товчлол), Антоон Мостаэрт ба монгол судлал. Уб., 2011
7. Н.Поппе. Алтай хэл шинжлэлийн удиртгал. Уб., 1999, 239-р тал
8. Б.Сумьяабаатар. Б.Нарангэрэл, Монголын нууц товчооны толь. Уб., 2008
9. Б.Сумьяабаатар. Монголын нууц товчоон, үсгийн галиг. Уб., 1990
10. Qad-un ündüsün quriyangγui altan tobči. Тэргүүн дэвтэр., галиглаж, үгийн хэлхээ үйлдсэн: Ш.Чоймаа Уб., 2002.
11. “Цаг хугацаа” сэтгүүл, Уб., 2003, № 03,7
12. Д.Баатар. Монгол хэлний үүсмэл үгийн тонгоруу толь. ӨМАХХ., 1988
13. Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. ӨМАХХ., 1987
14. Хорин наймт тайлбар толь. ӨМАХХ., 1988
15. Монгол хэлний тайлбар толь Уб., 2011
16. Andrew Radford, Martin Atkinson, David Britain, Herald Clahsen, Andrew Spencer, Linguistics an Introduction, New York, 2009
17. G.J.Ramstedt. Kalmückisches Wörterbuch. Helsinki. 1935
18. G.J.Ramstedt. Einführung in die Altaische Sprachwissenschaft, II Formenlehre, bearbeitet und herausgegeben Pentti Alto, Helsinki 1952
19. I.J.Schmidt. Grammatik der Mongolischen Sprache. St.Peterburg, 1831
20. Wörterbuch Deutsch-Mongolisch Langenscheidt, Verlag Enzyklopäde Leipzig, 1931
21. G.Luwan, D.Ariun, Kleines Wörterbuch Sprachwissenschaftlicher Termini UB., 2008
22. http://en.wikipedia.org/wiki/Altaic_languages

RESUME

Oppositeness of meaning is a pervasive semantic relation in the lexicons of human languages and it comes in several varieties. Thus, taking just *i-na-γsi* and *či-na-γsi*, we have the entailments in which make explicit that these are indeed semantic opposites: ‘X is inaru’ entails > ‘X is not činaru’; ‘X is činaru’ entails > ‘X is not inaru’